

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
05 дугаар сарын 22-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-6

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 7-12

1. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/ 7-12

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
05 дугаар сарын 22-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 08 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: А.Ундраа, С.Цэнгүүн, М.Энхцэцэг;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Баттулга;
Тасалсан: Ж.Алдаржавхлан, Э.Батшугар, Ж.Ганбаатар, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, М.Мандхай, О.Цогтгэрэл.

Нэг.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Батцэцэг, мөн газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Х.Сүрэнхорол, Салбарын бодлого, зохицуулалтын референт Б.Золбоо, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал С.Гантулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан ажлын 5 өдрийн завсарлага дууссан тухай мэдэгдэв.

Ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг 2025.05.06-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар санал хураалгаж, дэмжигдсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан 2, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан 2, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан 2, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан 2, Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан 1, дэмжигдээгүй Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан 1, Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан 2 зарчмын зөрүүтэй саналуудаа тус тус татан авав.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн зарчмын зөрүүтэй саналаа татан авав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Г.Уянгахишиг нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	6
Бүгд:	14

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 64.3 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Г.Уянгахишиг нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай 20.18, 20.19 дүгээр зүйлийг нэмсүгэй:

“20.18 дугаар зүйл.Төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх

1.Олон нийтийн газар, эсхүл мэдээллийн технологи ашиглан ашиг олох зорилгоор төлбөрт таавар, эсхүл бооцоот тоглоом зохион байгуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.

20.19 дүгээр зүйл.Мөрийтэй тоглоом, төлбөрт таавар, бооцоот тоглоомыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх

1.Мөрийтэй тоглоом, эсхүл төлбөрт таавар, эсхүл бооцоот тоглоомыг зохион байгуулах гэмт хэргийн үйлдэлд өөрийн, эсхүл бусдын нэр дээрх төлбөр тооцооны данс, цахим мөнгө, виртуал хөрөнгө, харилцаа холбооны сүлжээний дугаар, цахим тодорхойлогчийг удаа дараа ашиглуулах замаар дэмжлэг үзүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 6

Бүгд: 14

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Х.Ганхуяг нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 71.4 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дөрөв.Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Тав.Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зургаа.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Долоо.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Найм.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Г.Уянгахишиг нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хувь хүний” гэснийг “аж ахуйн нэгжийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 64.3 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Ес.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Г.Уянгахишиг нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хувь хүний орлогын албан татварын” гэснийг “жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 8
Бүгд: 14

42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 8

Бүгд: 14

42.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Р.Батболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 7

Бүгд: 14

50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан 15 цаг 28 минутаас 17 цаг 06 минутад завсарлав.

Хэлэлцэх асуудлын 2 дугаарт орсон “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлэгтэй холбогдуулан хуралдаанд оролцох сайдууд байхгүй байгаа тул уг асуудлын хэлэлцүүлгийг дараагийн хуралдаан хүртэл хойшлуулав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 22 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 08 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
15 цаг 08 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сэддорж, Бадамсүрэн, Батболд, Батнайрамдал, Батсүмбэрэл, Батчимэг, Бямбасүрэн, Лувсанжамц, Мөнхсоёл, Сайнзориг, Соронзонболд, Энхтүвшин нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Халтмаагийн Баттулга гишүүн эмнэлгийн чөлөөтэй, Ундраа гишүүн гадаад томилолттой, Цэнгүүн гишүүн орон нутгийн томилолттой, Энхцэцэг гишүүн гадаад томилолттой байна. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, ЗГ-аас 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай анхны хэлэлцүүлэг үргэлжилнэ. 2.Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл ЗГ-аас 2025 оны 4 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг. 3-д хэлэлцэх асуудалд орсон байсан Монголбанкны 2024 оны санхүүгийн тайлан, Даргын дэргэдэх зөвлөл дээр хэлэлцэх асуудлаас хасахыг дэмжсэн. Учир нь Монголбанкны Ерөнхийлөгч гадаад томилолттой байгаа учраас ирэх долоо хоногт хойшлуулж байна. Ийм 2 хэлэлцэх асуудал байна. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхээр Улсын Их Хурлын даргын дэргэдэх, сая хэлсэн. Ингээд хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Нэг.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 1.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулж эхэлье. Ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсэг Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Батцэцэг ЗГХЭГ-ын дэд дарга, Ганболдын Энхтайван Монголбанкны Дэд ерөнхийлөгч, Хаш-Эрдэнийн Сүрэнхорол ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын ЗГ-ын ахлах референт, Баатарчулууны Золбоо ЗГХЭГ-ын Салбарын бодлого, зохицуулалтын газрын референт, Сэнгээгийн Гантулга Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж эхлээд завсарласан байгаа. Ардчилсан намын бүлэг ажлын 5 хоногийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан. Ардчилсан намын бүлэг завсарлага сунгах эсэх талаар танилцуулъя. Алга байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийг баримтлан хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцье. Мөн зүйлийн 39.11 дэх хэсэгт заасны дагуу гишүүд тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асуух боломжтой.

1.Хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд байна уу? Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Баярлалаа хурал даргалагчаа. Тэгээд Ардчилсан намын бүлэг маань завсарлага авсан. Энэ хүрээнд үүсээд байгаа нөхцөл байдлыг бид ч гэсэн дүгнээд, эргээд энийг цаашдаа нэлээн сайн судалгаатай ултай суурьтай авч үзье гэдэг үүднээс хандаж байгаа учраас энэ удаад яг ЗГ-ын орж ирсэн төслөөр нь буюу энэ бооцоот тоглоом мөрийтэй тоглоомын асуудал бүрэн хориглочихъё. Энэ хориглолтын үйл ажиллагааг тодорхой түвшинд хэрэгжүүлээд, ер нь цаашдаа зүгээр ямар зохицуулалтыг хийх ёстой вэ гэдгээ нэлээн тийм судалгаатай хандъя гэж байгаа учраас Эдийн засгийн байнгын хороон дээр өмнөх хурлуудад хураалгасан Эдийн засгийн байнгын хороо дэмжчихээд байгаа Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль дээр 2 дугаар зүйлийг өөрчлөн найруулах саналаа татан авч байна. 3 дугаар зүйлийг хасах саналаа татан авч байна. Төслийн нэрийн нэмэлт гэснийг хасах саналаа татан авч байна.

Дээрээс нь Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийг өөрчлөн найруулах саналаа мөн татан авч байна. 2 дугаар зүйлийн нэмэлт гэснийг хасах саналаа татан авч байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн нэмэлт оруулах хуулийн төслийн талаарх гаргасан санал болгох 1 дүгээр зүйл буюу 10.1 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсгийн төлбөрт таавар, эсвэл бооцоот тоглоом эсвэл мөрийтэй тоглоом гэснийг мөрийтэй тоглоом эсвэл бооцоот тааврыг гэж өөрчилж байгаа саналаа татан авч байна. Төслийн 2 дугаар зүйлийн нэмэлт гэснийг хасах саналаа татан авч байна.

Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан саналаа 2 санал гаргасан энийгээ мөн татан авч байна.

Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулсан саналаа татан авч байна.

Мөн Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй байгаа Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийг хасах саналаа мөн татан авч байна. Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа дэмжээгүй саналаа 2 санал байх, 1 дүгээр зүйлийг өөрчлөн найруулах болон 2 дугаар зүйлийг хасаж байгаа саналуудаа тус тус татан аваад, зөрүүлээд найруулгын

шинжтэй хураалгах саналуудаа Байнгын хорооны зөвлөхөд өгчихсөн байж байгаа. Тэгээд тэр саналуудаар хурааж өгнө үү.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүн, Уянгахишиг гишүүн нар саналаа татан авсан тул. Төслийн 1 дүгээр зүйлийг хасах санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг. Санал хураалт явуулъя. Саналаа тайлбарлах уу? Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Нэгэнт ажлын хэсэг болон ажлын хэсгийн гишүүд саналуудаа татаж байгаа болохоор миний хувьд ч гэсэн энэ саналыг татахаар хурал даргалагчид мэдэгдэж байна.

Р.Сэддорж: Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Улсын Их Хурлын гишүүн, санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Уянгахишиг. Сайнзориг гишүүн саналаа тайлбарлах уу? Дагаж мөрдөх хугацаатай холбоотой заалт байгаа. Ингээд гишүүд санал хураалтад бэлдье. Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн, хасахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 57,1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Миний энэ юу ажиллахгүй байгаа учраас протоколд тэмдэглүүлэе.

Дараагийн, 2.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1 дүгээр зүйл.Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай 20.18, 20.19 дүгээр зүйлийг нэмсүгэй.

20.18 дугаар зүйл.Төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх.

1.Олон нийтийн газар, эсхүл мэдээллийн технологи ашиглан ашиг олох зорилгоор төлбөрт таавар, эсхүл бооцоот тоглоом зохион байгуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.

20.19 дүгээр зүйл.Мөрийтэй тоглоом, төлбөрт таавар, бооцоот тоглоомыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.

1.Мөрийтэй тоглоом, эсхүл төлбөрт таавар, эсхүл бооцоот тоглоомыг зохион байгуулах гэмт хэргийн үйлдэлд өөрийн, эсхүл бусдын нэр дээрх төлбөр тооцооны данс, цахим мөнгө, виртуал хөрөнгө, харилцаа холбооны сүлжээний дугаар, цахим тодорхойлогчийг удаа дараа ашиглуулах замаар дэмжлэг үзүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг. Сайнзориг гишүүн саналаа тайлбарлая.

П.Сайнзориг: Байнгын хорооны гишүүдээсээ энэ саналын томьёоллыг дэмжиж өгөхийг хүсэж байна. Тэгээд ерөнхийдөө ЗГ-аас орж ирсэн хуулийн төслийн үзэл баримтлалаа бариад асуудлуудыг жоохон тодруулаад, томьёоллыг оруулж байгаа. Ер нь олон нийтийн газар энэ цахим орчин буюу мэдээлэл технологи ашиглаад ашиг олох зорилгоор ямар нэгэн байдлаар мөрийтэй тоглоом, bet, казиногийн төрлийн тоглоом зохион байгуулахыг ерөнхийдөө Эрүүгийн хуулиар нэлээн ял хариуцлагыг нь өндөрсгөж байна.

2 дугаарт энэ үйл ажиллагаа дээр яах вэ бид нарын практикт нэрлэдэг буюу агентаар ажиллах дансаа ашиглуулдаг, эргээд энд бооцоо тавьж байгаа хүмүүсийн мөнгө төгрөгийг өөрийн дансаараа цуглуулаад тэр гадаад улс руу шилжүүлдэг энэ этгээдүүд энэ үйл ажиллагааг хийвэл эрүүгийн хариуцлагатай болж байгаа гэдэг зүйлийг би олон нийтдээ мэдээлэл өгөх зорилгоор хэлж байна. Үүнээс болж нийгэмд маш олон сөрөг үзэгдлүүд байгаа учраас ингэх, энэ үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцож хариуцлага тооцохоос өөр гарц байхгүй байгаа юм гэдэг зүйлийг энэ ташрамд хэлээд, энэ хураалгаж байгаа саналыг дэмжиж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Р.Сэддорж: Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Эрүүгийн хуульд 20.18, 20.19 дүгээр зүйлийг нэмье гэсэн саналын томьёоллоор, нэмэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 57,1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг, Бадамсүрэн нарын гишүүдийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай. Зөрчлийн тухай хуулийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Зөрчлийн тухай хуулийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан санал хэлэх, асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Уг хуулийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан санал хэлэх, асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна. Банкны тухай хуулийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна. Уг хуулийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна. Уг хуулийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Хамт өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна. Уг хуулийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг, Сайнзориг, Уянгахишиг нараас санал ирсэн. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “хувь хүний” гэснийг “аж ахуйн нэгжийн” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Уянгахишиг. Саналаа тайлбарлах уу? Ингээд найруулгын саналаар 1 дүгээр зүйлийн “хувь хүний” гэснийг “аж ахуйн нэгжийн” гэж өөрчлөх энэ өөрчлөлтийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 57,1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Миний төхөөрөмж ажиллахгүй байгаа учир дэмжиж протоколд тэмдэглэхийг хүсье. ААНОАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Хамт өргөн мэдүүлсэн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? 1 дүгээр зүйл дээр Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “хувь хүний орлогын албан татварын” гэснийг “жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Уянгахишиг. Тайлбар алга байна. Уг саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал гаргах гишүүд байна уу? Хассуурийн Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Энэ хурууны хээ таньсангүй л бололтой юм шиг байна. Дахиад санал хураалт явуулж өгнө үү.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг гишүүн төхөөрөмж ажиллахгүй байгаа тул санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна. Санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт. Улсын Их Хурлын гишүүн Батболд санал гаргах уу, гаргаж байна уу? Батболд гишүүн.

Р.Батболд: Төхөөрөмж ажиллахгүй байгаад байх юм, дахиж санал хураалтыг хүчингүй болгоод, дахиж хураалгаж өгнө үү гэж санал гаргаж байна.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Батболдын гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт. Санал 50 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Хамт өргөн мэдүүлсэн, хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг уншиж танилцуулна.

15.28 цаг

Дараагийн асуудалдаа оръё. Ажлын хэсэг яаралтай саналаа нэгтгэх шаардлагатай байгаа учраас 30 минут завсарлаж байна. Ингээд 30 минут, 16 цаг 00 минут.

Хуралдаан 15 цаг 28 минутаас завсарлаж, 16 цаг 44 минутаас үргэлжлэв.

Эрхэм гишүүдийн өдрийн амрыг эрье. Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31.2 дээр Засгийн газраас санаачилсан хуулийн төслийн танилцуулгыг Ерөнхий сайд эсвэл тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн, тухайн Засгийн газрын гишүүн түр эзгүй бол түүнийг орлож байгаа Засгийн газрын гишүүн хийнэ. 31.5 дээр энэ хуулийн 31.1, 31.2, 31.4-д заасан этгээд төслийн хэлэлцүүлгийн бүх үе шатанд оролцох үүрэгтэй ба хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд оролцоогүй бол тухайн хэлэлцүүлгийг дараагийн хуралдаан хүртэл хойшлуулна гэж заажээ. Ийм учраас сайдууд, ажлын хэсгээс асууя 1 номер. Сайдууд байгаа юу? Ажлын хэсэг хариулъя, 1 номер.

Б.Мөнгөнсүх: Байхгүй, байхгүй л байна.

Р.Сэддорж: Ийм учраас өнөөдрийн хуралдааныг хойшлуулж байна. Дараагийн хурал хүртэл.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

